



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/320/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Нямцэцэг Утас: 51-261885 Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn Азуре хүлүг худит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.21 № 07/623
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсаас Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мал эмнэлгийн ерөнхий газар, Эдийн засгийн хөгжлийн яам болон Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн, Япон улсаас Сүрьеэ судлалын хүрээлэн, Хоккайдогийн их

сургууль болон Зооноз судлалын судалгааны төвтэй хамтран "Сүрьеэ, ям өвчний хяналт" нэртэй САТРЕПС төслийг хэрэгжүүлж, "Био-аюулгүй байдлын 3 дугаар зэрэглэлийн иж бүрэн "лаборатори" байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн нь Монгол улсын хэмжээнд мал, амьтан нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд нөлөөлж болох халдварт, шимэгч болон халдваргүй өвчнийг оношлох, эмчлэх, сэргийлэх арга, технологи боловсруулах, суурь болон шинжлэх ухааны судалгаа хийх ажлын хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн захиалгат ажил, судалгаа хийх, олон улсын байгууллагуудтай хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх, мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарт итгэмжлэл олгох сургалт, судлаач нарыг судалгааны ажлаа гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тус хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл дүрмийнхээ дагуу 7 удаа ээлжит хуралдааныг зохион байгуулж 90 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>36,463,841.76</u>	<u>251,474,429.09</u>
33	АВЛАГА	2,444,080.00	195,861,112.58
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	168,080.00	271,113.25
33102	НДШ-ийн авлага	168,080.00	271,113.25
335	Бусад авлага	2,276,000.00	195,589,999.33
33510	Байгууллагаас авах авлага	-	195,589,999.33
3351013	Бусад зардлын тооцооны авлага	-	195,589,999.33
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,276,000.00	-
34	УРЬДЧИЛГАА	2,024,000.00	9,800,859.00
34700	Бусад урьдчилгаа	2,024,000.00	9,800,859.00
34710	Урьдчилгаа тооцоо	2,024,000.00	9,800,859.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	859.00
34714	Томилолтын урьдчилгаа	2,024,000.00	9,800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31,995,761.76	45,812,457.51
351	Түүхий эд материал	3,325,045.00	28,683,537.00
35110	Тусгай зориулалттай материал	3,325,045.00	28,683,537.00
35400	Хангамжийн материал	19,340,716.76	9,058,920.51
35410	Бичиг хэргийн материал	9,626,700.00	5,712,050.00
35420	Аж ахуйн материал	9,714,016.76	3,334,870.51
35440	Түлш, шатах тослох материал	-	12,000.00
35600	Мал амьтад	9,330,000.00	8,070,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,212,654,058.51</u>	<u>4,451,316,154.32</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,212,654,058.51	4,451,316,154.32
39200	Биет хөрөнгө	4,017,435,754.51	4,256,337,850.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,437,731,050.00	2,437,731,050.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(323,853,302.50)	(388,930,997.98)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	225,506,396.00	225,506,396.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(68,374,519.02)	(82,768,278.78)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,905,496,015.45	4,559,445,257.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,311,140,970.14)	(2,613,004,823.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	337,656,896.01	324,685,186.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(185,585,811.29)	(206,325,938.49)
393	Биет бус хөрөнгө	195,218,304.00	194,978,304.00
39301	Программ хангамж	1,200,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(480,000.00)	(720,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	194,498,304.00	194,498,304.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,249,117,900.27</u>	<u>4,702,790,583.41</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,591,491.92	18,130,113.25
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,591,491.92	18,130,113.25
413	Өглөг	1,591,491.92	18,130,113.25

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	600,000.00	600,000.00
41313	ХАОАТ-ын өглөг	600,000.00	600,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	263,079.92	17,221,701.25
413202	Гэрэл цахилгааны өглөг	-	17,221,701.25
413203	Түлш халаалтын өглөг	263,079.92	-
4136	Бусад өглөг	728,412.00	308,412.00
41361	Байгууллагад төлөх өглөг	728,412.00	308,412.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,247,526,408.35</u>	<u>4,684,660,470.16</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,247,526,408.35	4,684,660,470.16
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,459,914,824.05	3,459,914,824.05
51101	Өмч: - төрийн	3,459,914,824.05	3,459,914,824.05
512	Хуримтлагдсан үр дүн	249,502,023.73	686,636,085.54
51210	Өмнөх үеийн үр дүн	814,859,897.04	244,747,545.23
51220	Тайлант үеийн үр дүн	(565,357,873.31)	441,888,540.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	538,109,560.57	538,109,560.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,249,117,900.27</u>	<u>4,702,790,583.41</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>2,922,026,588.50</u>	<u>4,448,243,164.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,379,458.50	903,687,914.00
1200	Нийтлэг татварын бус орлого	34,379,458.50	903,687,914.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,840,000.00	1,320,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,840,000.00	1,320,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	27,674,210.00	902,275,914.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,865,248.50	92,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,887,647,130.00	3,544,555,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,120,716,502.00	2,772,936,866.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,120,716,502.00	2,772,936,866.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	766,930,628.00	771,618,384.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	477,589,150.00	589,510,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	289,341,478.00	182,108,034.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>3,487,384,461.81</u>	<u>3,998,790,892.13</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,487,384,461.81	3,998,790,892.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,424,864,883.81	3,948,287,344.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,798,061,851.27	2,340,241,395.88
210101	Үндсэн цалин	1,226,251,930.55	1,490,182,652.29
210102	Нэмэгдэл	316,700,737.27	547,575,254.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	159,101,296.86	273,238,738.00

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210104	Урамшуулал	96,007,886.59	29,244,751.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,467,451.43	292,439,135.58
210201	Тэтгэврийн даатгал	153,648,651.43	201,644,832.88
210202	Тэтгэмжийн даатгал	17,204,700.00	23,544,223.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,763,800.00	11,541,250.52
210204	Ажилгүйдлийн даатгал	3,440,900.00	11,335,528.10
210205	Эрүүл мэндийн даатгал	34,409,400.00	44,373,300.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,787,414.55	117,771,622.00
210301	Гэрэл, цахилгаан	41,433,499.41	79,503,590.06
210302	Түлш, халаалт	28,336,215.14	31,007,696.94
210303	Цэвэр, бохир ус	8,017,700.00	7,260,335.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,918,051.20	87,466,626.99
210401	Бичиг хэрэг	6,520,808.20	21,436,124.00
210402	Тээвэр, шатахуун	42,459,343.00	52,309,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	814,400.00	225,678.24
210404	Ном, хэвлэл	5,113,300.00	10,891,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,200.00	2,603,484.75
2105	Нормативт зардал	263,933,177.73	144,143,495.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	263,933,177.73	144,143,495.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,574,900.00	30,856,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	4,645,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,772,600.00	-
210604	Урсгал засвар	44,802,300.00	26,211,000.00
2107	Томилолт, зочны зардал	108,700,823.00	132,012,128.00
210701	Гадаад албан томилолт	2,000,000.00	3,824,598.00
210702	Дотоод албан томилолт	106,700,823.00	128,187,530.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	164,558,298.82	104,825,551.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,558,298.82	100,517,793.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	307,758.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	684,862,915.81	698,531,389.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,506,937.03	11,143,701.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	666,253,978.78	687,387,688.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,519,578.00	50,503,548.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,015,102.00	47,767,666.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,790,102.00	46,217,666.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,225,000.00	1,550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,504,476.00	2,735,881.49

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,595,406.44	1,532,158.49
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,909,069.56	1,203,723.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(565,357,873.31)</u>	<u>449,452,271.87</u>
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,563,731.56
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн	-	7,563,731.56
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,123,731.56
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	4,440,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(7,563,731.56)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(565,357,873.31)</u>	<u>441,888,540.31</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,888,879,130.00</u>	<u>3,541,975,250.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,888,879,130.00	3,541,975,250.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,120,716,502.00	2,772,936,866.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,120,716,502.00	2,772,936,866.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	768,162,628.00	769,038,384.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	477,589,150.00	589,510,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	290,573,478.00	179,528,034.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,830,137,430.00</u>	<u>3,510,323,170.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,830,137,430.00	3,510,323,170.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,767,617,852.00	3,266,819,621.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,798,394,463.91	2,340,073,315.88
210101	Үндсэн цалин	1,226,584,543.19	1,490,014,572.29
210102	Нэмэгдэл	316,700,737.27	547,575,254.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	159,101,296.86	273,238,738.00
210104	Урамшуулал	96,007,886.59	29,244,751.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,708,840.45	292,710,248.83
210201	Тэтгэврийн даатгал	153,890,040.45	201,915,946.13
210202	Тэтгэмжийн даатгал	17,204,700.00	23,544,223.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,763,800.00	11,541,250.52
210204	Ажилгүйдлийн даатгал	3,440,900.00	11,335,528.10
210205	Эрүүл мэндийн даатгал	34,409,400.00	44,373,300.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,586,499.41	100,823,000.00
210301	Гэрэл, цахилгаан	41,433,499.41	62,281,888.81

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210302	Түлш, халаалт	32,135,300.00	31,280,776.19
210303	Цэвэр, бохир ус	8,017,700.00	7,260,335.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,269,403.00	83,465,847.24
210401	Бичиг хэрэг	6,529,760.00	12,649,220.00
210402	Тээвэр, шатахуун	42,551,743.00	53,219,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	814,400.00	225,678.24
210404	Ном, хэвлэл	14,763,300.00	13,391,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,610,200.00	3,979,609.00
2105	Нормативт зардал	262,745,561.23	157,196,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	262,745,561.23	157,196,685.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,174,900.00	33,806,420.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	600,000.00	6,395,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,772,600.00	800,420.00
210604	Урсгал засвар	44,802,300.00	26,611,000.00
2107	Томилолт, зочны зардал	110,854,823.00	136,522,128.00
210701	Гадаад албан томилолт	3,000,000.00	9,824,598.00
210702	Дотоод албан томилолт	107,854,823.00	126,697,530.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	155,605,377.00	108,686,776.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	151,605,377.00	104,379,018.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	307,758.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,277,984.00	13,535,201.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,277,984.00	13,535,201.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,519,578.00	243,503,548.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,015,102.00	47,767,666.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,790,102.00	46,217,666.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,225,000.00	1,550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,504,476.00	195,735,881.49
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,595,406.44	1,532,158.49
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,909,069.56	194,203,723.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	58,741,700.00	31,652,080.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	58,741,700.00	31,652,080.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	58,741,700.00	31,652,080.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	58,741,700.00	31,652,080.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	58,741,700.00	31,652,080.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(58,741,700.00)	(31,652,080.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,459,914,824.05	538,109,560.57	814,859,897.04	4,812,884,281.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,459,914,824.05	538,109,560.57	814,859,897.04	4,812,884,281.66
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт	-	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(565,357,873.31)	(565,357,873.31)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,459,914,824.05	538,109,560.57	249,502,023.73	4,247,526,408.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(4,754,478.50)	(4,754,478.50)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,459,914,824.05	538,109,560.57	244,747,545.23	4,242,771,929.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт	-	-	-	-
Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	441,888,540.31	441,888,540.31
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,459,914,824.05	538,109,560.57	686,636,085.54	4,684,660,470.16

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,772,985,100.00	2,771,404,707.51	1,580,392.49	99.9
УРСГАЛ ЗАРДАЛ	2,772,985,100.00	2,771,404,707.51	1,580,392.49	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,725,119,200.00	2,723,637,040.95	1,482,159.05	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,297,900,700.00	2,297,894,761.88	5,938.12	100.0
Үндсэн цалин	1,414,965,100.00	1,447,836,018.29	(32,870,918.29)	102.3
Нэмэгдэл	777,484,400.00	547,575,254.59	229,909,145.41	70.4
Унаа хоолны хөнгөлөлт	104,456,900.00	273,238,738.00	(168,781,838.00)	261.6
Урамшуулал	994,300.00	29,244,751.00	(28,250,451.00)	2,941.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,237,600.00	290,113,842.83	1,123,757.17	99.6
Тэтгэврийн даатгал	199,161,600.00	199,319,540.13	(157,940.13)	100.1
Тэтгэмжийн даатгал	23,019,000.00	23,544,223.36	(525,223.36)	102.3
ҮОМШӨ-ний даатгал	11,509,500.00	11,541,250.52	(31,750.52)	100.3
Ажилгүйдлийн даатгал	11,509,500.00	11,335,528.10	173,971.90	98.5
Эрүүл мэндийн даатгал	46,038,000.00	44,373,300.72	1,664,699.28	96.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,823,000.00	100,823,000.00	-	100.0
Гэрэл цахилгаан	59,542,900.00	62,281,888.81	(2,738,988.81)	104.6
Түлш, халаалт	29,482,000.00	31,280,776.19	(1,798,776.19)	106.1
Цэвэр, бохир ус	11,798,100.00	7,260,335.00	4,537,765.00	61.5
Хангамж бараа материалын зардал	568,000.00	511,678.24	56,321.76	90.1
Бичиг хэрэг	59,700.00	-	59,700.00	-
Тээвэр, шатахуун	286,700.00	286,000.00	700.00	99.8
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	198,600.00	225,678.24	(27,078.24)	113.6
Ном, хэвлэл	13,000.00	-	13,000.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000.00	-	10,000.00	-
Эд хогшил, урсгал засварын зардал	30,000,000.00	29,986,000.00	14,000.00	100.0
Урсгал засвар	30,000,000.00	29,986,000.00	14,000.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,589,900.00	4,307,758.00	282,142.00	93.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	328,000.00	307,758.00	20,242.00	93.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,300.00	-	32,300.00	-
Газрын төлбөр	229,600.00	-	229,600.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,865,900.00	47,767,666.56	98,233.44	99.8

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Бусад урсгал шилжүүлэг	47,865,900.00	47,767,666.56	98,233.44	99.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,217,700.00	46,217,666.56	33.44	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,648,200.00	1,550,000.00	98,200.00	94.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,772,985,100.00	2,771,404,707.51	1,580,392.49	99.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,772,985,100.00	2,771,404,707.51	1,580,392.49	99.9
Улсын төсвөөс санхүүжих	2,772,985,100.00	2,771,404,707.51	1,580,392.49	99.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	94	94	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	80	80	-	100.0
Үйлчлэх ажилтан	13	13	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	769,038,384.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	769,038,384.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	574,834,661.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	42,178,554.00
210101	Үндсэн цалин	-	42,178,554.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,596,406.00
210201	Тэтгэврийн даатгал	-	2,596,406.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	82,954,169.00
210401	Бичиг хэрэг	-	12,649,220.00
210402	Тээвэр, шатахуун	-	52,933,840.00
210404	Ном, хэвлэл	-	13,391,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,979,609.00
2105	Нормативт зардал	-	158,076,685.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	158,076,685.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	32,267,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	31,467,080.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	800,420.00
2107	Томилолт, зочны зардал	-	136,522,128.00
210701	Гадаад албан томилолт	-	9,824,598.00
210702	Дотоод албан томилолт	-	126,697,530.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	106,704,018.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	106,704,018.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	13,535,201.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	13,535,201.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	194,203,723.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	194,203,723.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	194,203,723.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	769,038,384.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	769,038,384.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	589,510,350.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	179,528,034.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 6,980.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа..

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэсэн шинжилгээний ажлын 2,580.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэлд тусгаагүй байна.	1	2,580.0	1	2,580.0			1	2,580.0				
Бараа материалын дансанд 4,400.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ангилал зөрүүлж бүртгэсэн байна.	1	4,400.0			1	4,400.0	1	4,400.0				
Дүн	2	6,980.0	1	2,580.0	1	4,400.0	2	6,980.0				

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3.2 Аудитаар нийт 23,811.9 мянган төгрөгийн 8 зөрчил¹ илэрснээс, 340.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,149.4 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 18,322.5 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дотоод албан томилолтын зардлыг Сангийн сайдын 2024 оны 52 тоот тушаалд зааснаас 340.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.	1	340.0	1	340.0									
Бараа материалын зарлагын 4,730.2 мянган төгрөгийн ажил гүйлгээний шаардах хуудсанд барааны нэр болон хүссэн, зөвшөөрсөн, олгосон тоо хэмжээ байхгүй, санхүүгийн тамга, тэмдгээр баталгаажуулаагүй байна.	1	4,730.2					1	4,730.2					
Тайлант хугацаанд бараа материалын үлдэгдэлд өөрчлөлт ороогүй тэжээлийн хивэг, хорголжин тэжээл, туршилтын амьтны хивэг зэрэг нийт 2,242.0 мянган төгрөгийн аж ахуйн материал бүртгэлтэй байна.	1	2,242.0					1	2,242.0					
Санхүүгийн тайланд бүртгэлтэй 908.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	908.4			1	908.4							

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцэст 10,081.9 мянган төгрөгийн авлага, 908.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.	1	10,990.3					1	10,990.3			
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж (210801) эдийн засгийн ангиллаас 360.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.	1	360.0					1	360.0			
2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актын үлдэгдэл төлбөр 4,241.0 мянган төгрөгийг төлж барагдуулаагүй байна.	1	4,241.0			1	4,241.0					
Тайлант онд ур чадварын итгэмжлэлийн 4, сорилын итгэмжлэлийн 7 лабораторийн хийсэн сорил, шинжилгээний тоо хэмжээ, үр дүнд дотоод хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-					1	-			
Дүн	8	23,811.9	1	340.0	2	5,149.4	5	18,322.5			